

“МОНГОЛ МАЛЧИН” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Сайншанд

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
Зорилт 1.1. Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, малчдын мал маллах ухаан, аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг дэлгэрүүлсэн тэргүүний сумыг 2 жилд нэг удаа шалгаруулах.						
1	1.1.1. Малчдыг туршлага судлах арга хэмжээнд хамруулах /Малын чанар - Дэлгэрэх, Бэлчээр ашиглалт - Улаанбадрах, Хөвсгөл Малчдын бүлэг - Эрдэнэ, Малчдын хоршоо - Алтанширээ, бусад/	2020 - 2024			<p>“Малчдын нэгдсэн зөвлөгөөн”, “Залуу малчдын зөвлөгөөн”-ийг 2020-2022 онд 14 суманд зохион байгуулж, давхардсан тоогоор 3298 малчинд төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримталж буй бодлого шийдвэрүүдийг танилцуулсан. “Хүнсний хангамж аюулгүй байдал-мал аж ахуйн үндэсний чуулган”-д 14 сумын төлөөллийг хамруулж, малын чанар, түүхий эд бэлтгэлийн талаар мэдээ мэдээллийг хүргэсэн. Залуучуудыг мал маллах арга ухаанд сургах, ажлын хүрээнд “Адуучин” тэмцээнийг Дэлгэрэх суманд зохион байгуулж 14 сумаас 49 адуучин залуус оролцуулсан.</p> <p>Сумд залуу малчдыг дэмжих тэдгээрийг мал маллах арга ухаанд суралцуулах, зорилгоор сумын баяр наадам, залуу малчдын чуулган зэрэгт залуу малчдын дунд уралдаан тэмцээнийг зохион явуулж нутгийн ахмад настнууд суран эдлэлийг хийх талаарх арга туршлагыг залуу малчдад таниулж сурталчлан ажилласан. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлэх зорилгоор ногоон тэжээл бэлтгэх талаарх заавар зөвлөмжийг 14 сумын 130 малчинд хүргэснээс гадна Дэлхийн зөн олон улсын байгууллагын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөлтэй хамтран малчдын 45 төлөөллийг “Эрчимжсэн мал аж ахуй”, “Малын ногоон тэжээл тариалалт”, “Бордооны үйлдвэрлэл”, “Мод үржүүлгийн газар”, “4 улирлын хүлэмжийн аж ахуй”, “Хоршооны үйл ажиллагаа” зэрэгтэй танилцуулж, туршлага судлуулан мэдлэгийг нэмэгдүүлэн ажилласан.</p>	100%
2	1.1.2. Аймгийн хэмжээнд малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж “Өрхийн мэдээллийн сан”-тай болгох	2020 - 2024			<p>“Хүнсний аюулгүй байдал хөдөө аж ахуй” малчдын чуулга уулзалт-2022 улсын зөвлөгөөнд 14 малчныг оролцуулж мэдээ мэдээллээр хангасан. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, ажил олгогч эздийн холбоотой хамтран “Малчин-ажил олгогчдыг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулж 14 сумын 180 малчныг цахим сургалтад хамруулан туслах малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах тухай мэдээллийг хүргэсэн.</p> <p>Малчдыг дэмжих анхдугаар аяны хүрээнд аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, Мал эмнэлэгийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газартай хамтран</p>	100%

					“Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-ийг 14 сумын 70 гаруй малчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. Мөн малжуулах хөтөлбөрт хамрагдсан Дэлгэрэх, Мандах, Замын-үүд, Өргөн, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Даланжаргалан сумдын 24 залуу малчинд Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас сургалт зохион байгуулж мэдээллээр ханган ажилласан. Малын бүртгэлийн нэгдсэн санд 4494 малчин өрхийг улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.	
3	1.1.3. Залуу малчдад мал маллах, малын чанар, түүхий эдийн бэлтгэлийн талаар 2-5 хоногийн танхимын сургалтыг сум бүрд зохион байгуулах	2020 - 2024			Хадлан тэжээл бэлтгэх, ноос ноолуур бэлтгэх заавар зөвлөмжийг 14 сум болон багийн өдөрлөгөөр нийт 3298 малчин, мал бүхий иргэдэд, видео хэлбэрээр сумын Хөдөө аж ахуйн тасаг, орон нутгийн зар мэдээллийн цахим сайтаар давхардсан тоогоор нийт 166340 малчид, иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан.	70%
4	1.1.4. Аймгийн нийт малчин өрхийн нэгдсэн судалгаа, мэдээллийн программ нэвтрүүлэх, хөтлөх	2022 - 2023			Мал сүргийг дахин давтагдашгүй хувийн дугаартай болгон бүртгэлжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, бүртгэлээр дамжуулан мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, хяналт тавих тогтолцоог шинэ шатанд гаргах, олон улсын жишигт нийцүүлэх ажлыг эрчимжүүлэх, нийт малын сүргийн бүтэц, хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо, мал төллөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдол, шилжилт хөдөлгөөнийг хянах зорилгоор 14 сумын нийт 4494 малчин өрх болон 2,5 сая толгой малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан.	100%
5	1.1.5. Тэргүүн туршлага судлах, нэвтрүүлсэн шилдэг сумыг шалгаруулах	2021 - 2024			Сумдын хөдөө аж ахуйн тасгийн ажлыг сумын мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан байдал, бог малын хээлтүүлэгчийг бүртгэлжүүлсэн байдал, мэдээ, тайлан ирүүлсэн байдал, бог малын хээлтүүлэгчийг нийлүүлгийн бус үед эх сүргээс ялгасан байдал зэрэг үзүүлэлтээр үнэлэн 2020-2021 оны ажлын үзүүлэлтээр дүгнэн Даланжаргалан, Иххэт, Мандах, Хатанбулаг, Улаанбадрах сумдыг шалгаруулсан. Улсын тэргүүний шилдэг сумаар Хатанбулаг сум шалгарсан.	90%
Зорилт 1.2. Малчинд мэргэжлийн үнэмлэх, малчин өрхийн баталгааны тэмдэг олгох, хэрэглэхтэй холбогдсон хууль, журам, шаардлага, ач холбогдлыг таниулах.						
6	1.2.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгох	2020 - 2024			Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, баталгаажуулалтын 6857 ширхэг гэрчилгээ бичигдэж, адууны мах 236.9 тн, үхрийн мах 289.7 тн, хонины мах 497.6 тн, ямааны мах 211.6 тн, тэмээний мах 148.5 тн, гахайны мах 0.7 тн, 1789.5 тн ноос, ноолуур, 163160 ширхэг өндөг, 25877 ширхэг арьс шир, 25.0 тн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, 58559 толгой амьд малыг үзлэг, тандалтад хамруулж, бүтээгдэхүүнд шинжилгээ хийсэнд мал эмнэлгийн улсын 5 байцаагч хяналт тавьж баталгаажуулсан. Мал эмнэлгийн 87 гэрчилгээ батлагдаагүй, 46 гэрчилгээг татгалзаж, саатуулсан 3 нийт 136 ш цахим гэрчилгээ буюу 2 хувь нь зөрчилтэй байгааг тухай бүр хяналтад авч, ашиглалтыг	90%

				сайжруулсан. Малын эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх 20 удаагийн цахим, 17 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 323 эмч, мэргэжилтэн, төрийн албан хаагч, малчдын төлөөлөл 747 иргэнийг хамруулан, 63 төрлийн гарын авлага материал 8200 ширхгийг олгосон.	
Зорилт 1.3. Мэдээлэл харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан малчдад хэрэгцээт мэдээллийг шуурхай хүргэх, энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглахад сурган хүртээмжийг нэмэгдүүлж орон зайн хамаарлыг бууруулах.					
7	1.3.1. “Масс мессеж” үйлчилгээ хүргэх	2020 - 2024		Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээллийг малчдад шуурхай хүргэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар 9,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж Мобиком, Скайтел компаниудтай “Масс мессеж” үйлчилгээг хүргэх гэрээг шинэчлэн байгуулсан. Байгаль, цаг уурын аюулт үзэгдэл болох цасан болон шороон шуурга, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэрэмжлүүлэх болон цаг үеийн мэдээллийг давхардсан тоогоор 311193 иргэд, малчдад цаг алдалгүй хүргэн ажилласан.	100%
8	1.3.2. Үүрэн холбооны газруудтай хамтран мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглан сургалт, мэдээллийг малчдад хүргэх	2020 - 2024		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, ажил олгогч эздийн холбоотой хамтран “Малчин-ажил олгогчдыг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулж 14 сумын 180 малчин цахим сургалтад хамрагдаж туслах малчинтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллах тухай мэдээллээр хангасан. Алслагдсан хүн ам, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор 2019-2021 онд Мандах, Айраг, Алтанширээ, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумууд Эрүүл мэндийн яам, Орон нутгийн хөгжлийн сангийн 90,7 сая төгрөг, Хатанбулаг сум, Зүүнбаян сум баг, Борхойн наран өрхийн эрүүл мэндийн төвүүд орон нутгийн хөгжлийн сан, улсын төсвийн 48,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мобайл технологийн тоног төхөөрөмжүүдтэй болсон.	90%
1.4. Гэрээт болон туслах малчдад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах					
9	1.4.1. Гэрээт болон туслах малчдын судалгаа хийж, сан үүсгэн хөтлөх	2020 - 2024		Аймгийн Засаг даргын 2020 оны А/462 дугаар захирамжаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа авах ажлыг зохион байгуулах комисс байгуулсан. Нийт сумдын малчдын 30 хүртэлх хувийг хамруулан туслах малчны эрэлт хэрэгцээг тогтоох судалгааны ажил 14 суманд судалгааны ажил хийсэн. Цөөн малтай 154 малчин өрх, гэрээт болон аман гэрээгээр ажиллаж байгаа ганц бие 19 туслах малчин байгаа судалгааны үр дүнгийн мэдээлэл гарсан. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хот хөдөөгийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хот, суурин газраас орон нутагт шилжиж мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллах сонирхолтой өрхийг малжуулах, гэрээт малчнаар ажилд зуучлах ажлын хүрээнд 14 сумын 211 малчнаас 350 туслах малчин ажиллуулах захиалга авсан.	100%
10	1.4.2. Мал аж ахуй,	2022		Хөдөлмөрийн хуулиар туслах малчинтай байгуулах гэрээ батлагдсан тул орон нутагт	100%

	орон нутгийн онцлогт тохируулан туслах малчдын хөдөлмөрийг үнэлэх, харилцааг зохицуулах журам батлан мөрдүүлэх			туслах малчин ажиллуулах журам боловсруулах шаардлагагүй болсон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, ажил олгогч эздийн холбоо, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран Хөдөлмөрийн хуулийг танилцуулж “Малчин-ажил олгогчдыг чадавхжуулах”, “Малчдын эвлэлдэн нэгдэх эрх, хамтын гэрээ хэлэлцээр нийгмийн хамгааллыг дэмжих” нь сэдэвт 2 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулж 14 сумын давхардсан тоогоор нийт 250 малчныг хамруулж, малчдын хөдөлмөрийг үнэлэх, харилцааг зохицуулах тухай, туслах малчинг хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулах тухай мэдээллээр тус тус хангасан. Хөдөлмөрийн хуулиар малчин ажил олгогч болж туслах малчин авч ажиллуулахад гэрээ байгуулж нийт 5 сумын 19 малчин гэрээ байгуулан ажилласан.	
11	1.4.3. Гэрээт болон туслах малчидтай уулзалт, арга хэмжээг бүсчлэн зохион байгуулах	2021 - 2024		Аймгийн малчдын нэгдсэн зөвлөгөөнд 14 сумын туслах малчдын төлөөллийг оролцуулж санал бодлыг сонсох, туршлага судлах ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.	50%
2.1. Сумдын мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрүүлэн бэлтгэх, нийлүүлэх малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөлийг дэмжих.					
12	2.1.1. Хөдөө аж ахуйн сургагч багш бэлтгэх, давтан сургаж чадавхжуулах	2021 - 2024		Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй "Гамшигт тэсвэртэй орон нутаг" төслийн хүрээнд Мал эмнэлгийн газар, Дэлгэрэх, Эрдэнэ, Хатанбулаг сумдын 11 мэргэжилтнийг "Оролцооны эпидемиологи" чиглэлээр хөдөө аж ахуйн малын эрүүл мэндийг хамгаалах сургагч багшаар бэлтгэсэн.	70%
13	2.1.2. Сургагч багш нараар дамжуулан малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөлийг мэргэжил арга зүйгээр хангах	2020 - 2024		Айраг, Даланжаргалан, Мандах, Сайншанд сумдын малчдын зөвлөгөөний үеэр болон Хоршоо хөгжүүлэх сангийн сургалтаар нийт 540 гаруй малчдад хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаа, малчдын хувь нийлүүлсэн оролцоотой хоршоо, нөхөрлөл байгуулах талаар танилцуулж, итгэмжлэгдсэн агуулахын төлөөлөгчөөр 9 сумын 3 иргэн, 6 хоршоо, 2 аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Алтанширээ сумын "Олон ширээ" хоршоог загвар хоршоо болгохоор гишүүдийн тоо нэмж 107 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.	70%
14	2.1.3. Хоршоо, нөхөрлөл байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	2020 - 2024		Алтанширээ сумын “Олон ширээ” хоршоо нь “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас мал чанаржуулах, махыг үйлдвэрийн аргаар бэлтгэх чиглэлээр 80.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч шинээр 2 ажлын байр бий болгосон. Замын-Үүд, Иххэт, Мандах, Даланжаргалан сумд Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олгохоор төсөл сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангасан. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу 4 сумын 13 аж ахуйн нэгж, байгууллагын төсөлд 4 шатны үнэлгээ явагдаж 4 аж ахуйн нэгж	100%

				байгууллагад 500,0 сая төгрөгийн зээлийг олгосон.	
Зорилт 2.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг малчин, мал бүхий өрх тус бүрээр тодорхойлох, чанарыг үнэлэх, баталгаажуулах.					
15	2.2.1. Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэн, хөтлөх	2020 - 2024		<p>Малын эрүүл мэндийн цахим системийг нэвтрүүлсэнтэй холбоотой 14 сумын Мал эмнэлгийн тасагт Samsung Galaxy Tab A-14 ширхэг, зөөврийн принтер-14 ширхгийг олгосон. Мал малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг малчин, мал бүхий өрх тус бүрээр тодорхойлох, чанарыг үнэлэхээр хяналт шалгалтыг 14 сумын мал эмнэлгийн үйлчилгээний 33 аж ахуй нэгжид 2 удаа, мал эрүүлжүүлэн тусгаарлах бүсэд 3 удаа, тахианы аж ахуйд 2 удаа, малын эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэгч 1 аж ахуй нэгжид 1 удаа тус бүр зохион байгуулан нийт 8 зөрчлийг илрүүлж, арилгуулсан.</p> <p>Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулж, үүргээ гүйцэтгэсэн байдалд гоц халдварт, халдварт өвчний нийт 5 удаагийн хяналтад 220 малчныг хамруулан, шатахуунд 550.0 мянган төгрөг зарцуулснаар малчдын мал сүргээ эрүүл байлгах, түүний ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэн ажилласан. Мал эмнэлгийн нэгдсэн системийг 100% нэвтрүүлсэн.</p>	100%
16	2.2.3. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, чанарын талаар тусгай нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх	2021 - 2024		<p>Мал аж ахуйн үйлдвэрлэлийг биотехнологийн ололттой хослуулан хөгжүүлэх, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, нутгийн гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг олон нийтэд сурталчлан таниулах, малчид, үйлдвэрлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж урамшуулах, харилцан туршлага солилцох зорилго бүхий “Шилмэл мал-2022” үзэсгэлэн худалдааг 9 дүгээр сард зохион байгуулсан.</p> <p>Улсын “Шилмэл мал-2022” гойд, ашиг шимт малын цахим үзэсгэлэн худалдаа 10 дугаар сард зохион байгуулагдаж тус үзэсгэлэн худалдаанд адуу, ямааны төрөлд Дэлгэрэх, Сайхандулаан сумын 8 малчин өрхийн 12 толгой мал оролцож, Дэлгэрэх сумын 3-р багийн аймгийн Аварга малчин Н.Санжидын Дэлгэрэхийн улаан омгийн эм ямаа “Гойд ашиг шимт мал”-аар шалгарч амжилттай оролцсон ба залуу малчдад мал маллах арга ухаан, туршлагын талаар танилцуулсан богино хэмжээний нэвтрүүлгийн бэлтгэлийг ханган ажилласан.</p>	90%
Зорилт 2.3. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, гарал үүслийг баталгаажуулан малчдын гар дээрээс хэрэглэгчдэд шууд хүргэх арга хэмжээ авах.					
17	2.3.1. Малчдын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	2021 - 2024		<p>Орон нутгийн газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүн, нутгийн малын үүлдрийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг Сайншанд суманд зохион байгуулсан.</p> <p>Үзэсгэлэн худалдаанд 14 сумын 195 иргэн, аж ахуйн нэгж, 50 гаруй малчин оролцож 15 төрлөөр шилдгүүдээ тодруулж, 119,7 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн. “Язгуур алтан өв” соёлын биет бус өвийн анхдугаар үзлэг, наадам, Соёл, урлагийн газрын Нээлттэй</p>	100%

				хаалганы өдөрлөгөөр өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилсан. Мөн Улсын "Шилмэл мал-2022" гойд, ашиг шимт малын цахим үзэсгэлэн худалдаа 10 дугаар сард зохион байгуулан ажилласан.	
18	2.3.2. Малчдын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчилах нэгдсэн цэг байгуулах	2021 - 2024		<p>Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 6 иргэн, 1 аж ахуйн нэгж, 4 хоршоо, арьс, ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр 2 иргэн үйл ажиллагаа явуулж, орон нутгийн иргэдийн захиалгын дагуу бэлэн хувцас, бэлэг дурсгалын зүйл, хонины элдсэн нэхий, хурганы арьс, үстэй дээл, монгол гэрийн эсгий дээвэр, гудас зэргийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн.</p> <p>“Цагаан сүүний буян” ХХК Сүү сүүн бүтээгдэхүүнийг нэрийн болон Эргэл зах, мөн Дорноговь-Номин салбараар борлуулах үйл ажиллагааг дэмжиж ажилласан. Алтанширээ сумын “Олон ширээ” хоршоо нь тогтвортой ноос ноолуурын холбооны гэрчилгээ авч хоршооны гишүүдийн бэлтгэсэн 40 тн ноолуурыг ангилан ялгаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Гоёл” үндэсний үйлдвэрт нийлүүлж, Төв лабораторийн гэрчилгээ авсан.</p>	90%
3.1. Малчин өрх, малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, нөөц ашиглалтын нэмэгдүүлэх хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.					
19	3.1.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах тоног, төхөөрөмжийг нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх	2022 - 2023		<p>Дэвжих эсгий ХХК нь гэрийн эсгий үйлдвэрлэх чиглэлээр сум хөгжүүлэх сангаас 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч тоног төхөөрөмж авснаар 2м*5м харьцаатай эсгий өдөрт 40-50 ширхгийг үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байнгын ажлын байр 3, түр ажлын байр 2, нийт 5 ажлын байр бий болгон үйл ажиллагаагаа явуулсан.</p> <p>Өргөн суманд хувиараа аж ахуй эрхлэгч иргэн тус сумын болон бусад сумдын малчидтай гэрээ байгуулан бүтээгдэхүүн болон бэлэн мөнгөөр түүхий эдээ худалдан авч 145 ширхэг эсгий үйлдвэрлэн борлуулсан.</p>	70%
Зорилт 3.2. Малчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд жил бүр хамруулах.					
20	3.2.1. Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн багийн түвшинд ажиллуулж малчдыг үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хамруулах	2021 - 2024		<p>Малчдын эрүүл мэндийг дэмжих, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд шүдний эмчийн явуулын үзлэгийг 5 суманд зохион байгуулж, 908 хүнийг хамруулж аймгийн Засаг даргын захирамжаар 10,8 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Үзлэгт 0-18 насны хүүхэд 670 /73.7%/, 19-аас дээш насны иргэн 238 /26.2%/ хамрагдсанаас 836 хүнд шүдний өвчлөл илрүүлж, 1369 шүдэнд эмчилгээ хийж, 706 хүнийг /84.4%/ эрүүлжүүлсэн. Хөдөөгийн малчин иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн Мобайл технологийн тоног төхөөрөмжийг нийт 10 сум, 1 өрхийн эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн. 2022 оны байдлаар мобайл үзлэгт хөдөөгийн хүн амын 36,1% буюу 5293 иргэн хамрагдаж, 319 өвчлөл шинээр илрүүлэн дээд шатлалд 192 хүн илгээж, 115 хүний эмчилгээний асуудлыг шийдсэн.</p> <p>Хорт хавдрын 8 тохиолдлыг эрт үед илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 38 хүнийг зайн оношилгоогоор оношилж, арьсны эмгэгтэй 16 хүний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Сумдын 14 багт дотрын 4, хүүхдийн 3, эх барих эмэгтэйчүүдийн 2,</p>	100%

				уламжлалтын 3, дүрс оношилгооны 1 нийт 13 их эмч хөдөөгийн хүн амд нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагууд отор нүүдлийн айл өрхөөр урьдчилан сэргийлэх үзлэг, түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээг цаг алдахгүй үзүүлж, үзлэгт 79,3%-ыг хамруулж, эрүүл мэндийн даатгалаар үнийн хөнгөлөлттэй олгох эмийн үйлчилгээ болон бусад тусламжийг үнэ төлбөргүй, чирэгдэлгүй үзүүлж ажилласан.	
21	3.2.2. Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд Мобайл технологи /тоног төхөөрөмж/ нэвтрүүлж малчдын орон зайн хамаарлыг бууруулах	2020 - 2024		<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын алсын зайн оношилгооны чадавхыг нэмэгдүүлж, хөдөөгийн малчид иргэд хаана байгаагаас үл хамааран эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор мобайл технологийг нэвтрүүлсэн. 2022 оны байдлаар нийт 10 сум буюу аймгийн 76,9% нь өрхийн эрүүл мэндийн төв Мобайл технологийн тоног төхөөрөмжтэй болсон.</p> <p>Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 49 эмч мэргэжилтнийг багаар нь орон нутгийн сургалтад хамруулан чадавхжуулсан. Үлдсэн 4 суманд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар мобайл технологийн тоног төхөөрөмжийг нийлүүлснээр 2022 онд багтааж 100%-д хүргэхээр бэлтгэл ажлыг хангасан. Мобайл үзлэгт хүн амын 36,1% буюу 5293 хүнийг хамруулж, 2318 шинжилгээ хийж, 319 өвчлөл шинээр илрүүлж, дээд шатлалд 192 хүн илгээж, 115 хүний эмчилгээний асуудлыг шийдэж, 8 хавдар эрт шатанд нь илрүүлж, зүрх судасны эмгэгтэй 38 хүнийг зайн оношилгоогоор дамжуулалт хийж оношилж, арьсны эмгэгтэй 16 хүнийг Арьс судлалын үндэсний төвтэй зайнаас холбогдон оношилгоо эмчилгээг шийдвэрлэснээр хөдөөгийн малчид жилдээ нэг удаа сумандаа оношилгоо шинжилгээг хийлгэх боломжийг бүрдүүлсэн.</p>	100%
3.3. Малчин өрхийн гишүүдийг насан туршийн боловсролын төв, нэгжүүдээр дамжуулан, боловсрол, мэдлэг чадвар олгох, бага насны хүүхдүүдэд эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоотойгоор СӨБ эзэмшүүлэх,					
22	3.3.2. Малчин залуу эцэг, эхчүүдэд хүүхэд хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, сургах арга барил эзэмшүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2021 - 2024		Насан туршийн боловсролын төв, малчдын нэгдсэн сургалт, өдөрлөгийн хүрээнд сумд "Гэр бүлийн үнэ цэнэ", "Охидын эрх, үүрэг, тулгамдаж буй асуудлууд", "Хүмүүжлийн эерэг арга", "Гэр бүл хүчирхийлэл", "Хүүхэд хамгаалал" зэрэг сэдвүүдийн хүрээнд давхардсан тоогоор 4000 гаруй малчин, 244 хүүхэд хамруулан, хүмүүжил төлөвшлийн арга хэмжээг зохион байгуулсан.	90%
23	3.3.3. Малчин өрхийн 2-5 насны хүүхдэд чиглэсэн "Шинэ үсгийн багш" хөтөлбөрийг	2021 - 2024		Сумдын алслагдсан болон отор нүүдэлд явсан айл өрхийн 2-5 насны 125 хүүхдийг зуны хувилбарт сургалтанд, малчин, мал бүхий иргэдийн 2-оос 5 насны 223 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын төв, гэр цэцэрлэгт хамруулсан.	70%

	хэрэгжүүлэх					
Зорилт 3.4. Улс, аймгийн аварга малчдыг тодорхойлох, шалгаруулахад орон нутгийн орлого багатай өрхүүдийг малжуулах, ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэсэн бодит нотолгоо олгох зохицуулалтыг бий болгох.						
24	3.4.1. Аварга малчдын сүүлийн 3 жилд малжуулсан малчин, мал бүхий өрхийн А дансны бүртгэлээр баталгаажуулах	2021 - 2024			Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан мал сүргээ 5 төрөл дээр нь тогтвортой өсгөн үржүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлэн, малч ухаан, ажиллах арга туршлагаараа манлайлан ажилласан "Улсын хошой аварга малчин" 1, "Улсын аварга малчин өрх" 8, "Алтан төлийн эзэн" 5, "Аймгийн хошой аварга малчин өрх" 11, "Аймгийн аварга малчин өрх" 48, "Аймгийн аварга тэмээчин" 3 нийт 76 аварга малчныг тодруулсан. Улс, аймаг, сумын тэргүүний малчид нийт 125 өрхийг малжуулан 12250 толгой малыг А дансанд бүртгүүлж баталгаажуулсан.	100%
25	3.4.2. Орон нутагт ядуурлыг бууруулахад аварга малчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах	2021 - 2024			Улс, аймгийн аварга малчдыг тодорхойлох, шалгаруулахад орон нутгийн орлого багатай өрхүүдийг малжуулах, ядуурлыг бууруулахад оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэсэн бодит нотолгоо олгох зохицуулалтыг бий болгосон. Сумдын малчдын нэгдсэн зөвлөгөөнд улс, аймгийн аварга малчдын журмын дээрх зохицуулалтыг 3298 малчдад танилцуулснаар, тэргүүний малчид нийт 125 өрхийг малжуулан 12250 толгой малыг А дансанд бүртгэлээр баталгаажуулсан.	100%
Зорилт 4.1. Бэлчээрийг зохистой ашиглах, ашиглалтыг сайжруулах, хамгаалах менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх.						
26	4.1.1. Бэлчээр ашиглалтын журам батлан хэрэгжүүлэх	2021 - 2024			Айраг, Өргөн, Мандах, Улаанбадрах, Сайхандулаан, Хөвсгөл, Сайншанд сумд орон нутгийн онцлогтоо тохируулан бэлчээр ашиглах, отор нүүдэл зохицуулах журмыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. Айраг, Сайншанд сумдын "Бэлчээр ашиглах журам"-ыг 2022 онд Хууль зүйн яамны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлсэн. Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08/06 дугаар тогтоолоор бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг баталж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлэн ажилласан.	90%
27	4.1.2. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	2021 - 2024			Даланжаргалан, Өргөн, Хөвсгөл, Улаанбадрах, Мандах, Сайхандулаан, Эрдэнэ сумд орон нутгийнхаа онцлогт тохирсон бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гарган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулсан. Тус онд Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08/06 дугаар тогтоолоор Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг баталж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлсэн. Даланжаргалан, Иххэт сумд орон нутгийн онцлогтоо тохируулан бэлчээр ашиглах журам, менежментийн төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулахаар журам, төлөвлөгөөний төсөлд иргэдээс санал авах, багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх ажлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	70%
28	4.1.3. Ус, бэлчээр ашиглалтын холбоо, бүлэг байгуулах	2021 - 2024			Дэлхийн зөн" ОУБ-аас хэрэгжүүлж буй "Гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Эрдэнэ, Дэлгэрэх сумдад малын тэжээлийн ургамал тариалах 2 иргэд малчдын бүлгийг байгуулж, туршилтаар 2 га талбайд ногоон тэжээл тариалж 2.3 тн ногоон тэжээл	90%

				хураан авсан.	
Зорилт 4.2. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан өсгөх					
29	4.2.1. Аймгийн хэмжээнд бэлчээрийн даацын багтаамж, ашиглалт, хэтрэлтийн төлөв байдлыг судлах	2020 - 2024		<p>Бэлчээрийн газрын өөрчлөлтөд фото мониторинг хийх журам, аргачилсан зааврын дагуу бэлчээр ашиглалтын нөлөөлөлд фото мониторингийн аргаар хяналт хийх ажлыг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээр 14 сумын 54 багийн хяналтын 72 зогсоол цэгт 8 дугаар сард судалгааг хийж бэлчээрийн даац, хүрэлцээтэйг тодорхойлуулан дүгнэлтийг гаргуулсан.</p> <p>Бэлчээрийн даацад тулгуурлан аймгийн хэмжээнд отор нүүдлийн зураглалыг гаргаж холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр ханган, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг зохион байгуулах бэлтгэж ажлыг хангасан.</p>	100%
30	4.2.2. Бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг зах зээлд нийлүүлэх	2020 - 2024		<p>Энэ оны байдлаар 4665 малчин өрхийн (758364 төл хүлээж авсан) нийт 3,0 сая толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан төлөвтэй байна. 2022-2023 онд хонин толгойд шилжүүлснээр 14 сумын нийт 434,6 мянган толгой малыг хүнсэнд хэрэгцээлэх болон зах зээлд борлуулах ажлыг сум бүр зохион байгуулах ажиллах бэлтгэлийг хангасан.</p> <p>Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ сумд бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг хүнсэнд буюу зах зээлд нийлүүлэх зорилгоор Хэнтий аймгийн мал мах бэлтгэдэг 2 аж ахуйн нэгжтэй хамтран мах бэлтгэх ажлыг зохион байгуулж кг тутмыг хонь 5500, адуу 4500, ямаа 4000 төгрөгөөр, Суман зурхай ХХК үхрийн махыг 8000 төгрөгөөр тус тус худалдан авсан.</p>	90%
Зорилт 4.3. Бэлчээр дэх худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлэх					
31	4.3.1. Бэлчээр дэх худаг, уст цэгийн ашиглалтын судалгаа гаргах, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах	2020 - 2024		<p>Бэлчээрт инженерийн хийцтэй 476, богино яндант 29, бетон хашлагт 534, энгийн уурхай 2163 нийт 3202 худаг ашиглагддаг судалгаа гарсан.</p> <p>Зарим сумдын худгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор Айраг, Алтанширээ, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд сумдын инженерийн хийцтэй 8 худаг, Айраг, Хатанбулаг сумдын 12 гар худгийг малчдын оролцоотойгоор сэргээн засварласан.</p>	90%
32	4.3.2. Инженерийн хийцтэй худаг шинээр болон сэргээн засварлах	2020 - 2024		<p>Улсын төсвийн 157,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барих 5 инженерийн хийцтэй худгийн ажлыг Эхний эхэн ХХК-аар 60 хувийг гүйцэтгүүлэн ажилласан.</p> <p>Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Улаанбадрах, Мандах, Сайхандулаан, Замын-үүд, Хөвсгөл, Эрдэнэ сумдын Орон нутгийн хөрөнгийн сангийн 599,2 сая төгрөгийн хөрөнгөөр 29 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргах ажил хийгдсэн. Айраг, Хатанбулаг сумд Орон нутгийн хөрөнгийн сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр 12 гар худгийг малчдын оролцоотойгоор сэргээн засварласан. Дээрх 46 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 69 мянган га бэлчээрийг усжуулж 75.6 мянган толгой малыг услах боломж нөхцөл бүрдсэн.</p>	100%
33	4.3.3. Гар худаг шинээр болон сэргээн засварлах	2020 - 2024		<p>Айраг, Хатанбулаг сумд Орон нутгийн хөрөнгийн сангийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр 12 гар худгийг малчдын оролцоотойгоор сэргээн засварласан. Нийт 12 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 12 мянган га бэлчээрийг усжуулж 15,3 мянган толгой</p>	90%

				малыг услах боломжийг бүрдүүлсэн.	
4.4. Бэлчээрт хор хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээ авах					
34	4.4.1. Бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгч амьтны судалгаа хийх	2020 - 2024		Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамтай байгуулсан гэрээний дагуу Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 2022 оны “Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хөнөөлт мэрэгчдийн хаврын тодотгох судалгааны ажлыг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх сумдын нутгийг хамруулан хийж гүйцэтгэсэн. Хаврын тодотгох судалгаагаар дээрх 5 сумын бэлчээрийн нутагт 153000 га талбайд буюу бэлчээрийн газрын талбайн 26.5 хувьд нь хөнөөлт мэрэгч болох “Үлийн цагаан оготно”-ы тархалт нягтшил нь хэсэгчилсэн болон үргэлжилсэн тархалттай гэсэн зөвлөмж дүгнэлт гарсан.	100%
35	4.4.2. Судалгааны үр дүнд тулгуурлан мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх ажлыг орон нутгийн малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран зохион байгуулах	2020 - 2024		Мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх шаардлагатай 74000 га талбайд үлийн цагаан оготно олширч тархалт нягтшил нь ихэссэн тул улсын төсвийн зардлаар, энгийн механик, биологи, микробиологийн аргаар тэмцэх ажлыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлан, сум тус бүрд ажлын хэсэг байгуулан богино хугацаанд тэмцэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд санал хүргүүлсэн. Малчид хувиараа болон хоршоо, нөхөрлөлийн хэмжээнд 5 мянга орчим га бэлчээрт үлийн цагаан оготно устгах ажлыг гар аргаар зохион байгуулсан.	50%
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ					88.85%

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Ж.НАРАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
МАЛ ҮРЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА
МЭРГЭЖИЛТЭН
МЭРГЭЖИЛТЭН

Н.НАРАНБАЯР
Б.АЮУШ
Д.ОТГОНЧИМЭГ